



ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

МУУУИТ-ын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай 01 дүгээр албан даалгаврын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд нийт уран бүтээлч, албан хаагчдын гэр бүл, хүүхдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсролын ач холбогдлыг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, хүүхдэд ээлтэй байгууллага, хамт олныг бий болгох дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий МУУУИТ-ын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	М.Бямбаа	(Бүжигчин)
Тэргүүлэгч:	Г.Одмаа	(Хөгжимчин)
Гишүүд:	Ц.Гантуяа	(Дуучин)
	Х.Батням	(Хөгжимчин)
	О.Цог-Юүрэн	(Тайзны механикч)
Нарийн бичийн дарга:	Г.Эрдэнэбулган	(Аж ахуйн нярав)

2. МУУУИТ-ын “Эцэг эхийн зөвлөл”-ийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлуулж, ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг МУУУИТ-ын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн дарга (М.Бямбаа)-д үүрэг болгосугай.

3. МУУУИТ-ын “Эцэг эхийн зөвлөл”-өөс санаачлан зохион байгуулсан үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллахыг Албадын дарга нарт үүрэг болгосугай.

